

МОНГОЛЫН ЭМ СУДЛАЛ, ЭМ НАЙРЛАГЫН ТАЛААР ГАДААДЫН СУДЛААЧДЫН БИЧСЭН ЭРТНИЙ БҮТЭЭЛИЙГ ТОДРУУЛАХ НЬ

М.Хастана¹, Б.Гэрэлмаа², Ч.Чимэдрагчаа³, Ш.Болд⁴
^{1,2}“Ач” АУИС,

³Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн

⁴Уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын хүрээлэн

CLARIFICATION OF ANCIENT WORKS WRITTEN BY FOREIGN RESEARCHERS ON MONGOLIAN PHARMACOLOGY AND PHARMACEUTICAL FORMULATION

Khastana.M¹, Gerelmaa B², Chimedragchaa Ch³, Bold.Sh⁴
^{1,2}“Ach” Medical University,

³Institute of Traditional Medicine and Technology

⁴Traditional Medical Research Institute

Abstract

In recent years, the study of pharmacology and pharmaceutical formulation of traditional Mongolian medicine has been developing significantly. However, there are few research papers on Mongolian pharmacology and development of pharmaceutical formulation written by foreign researchers in ancient times. Therefore, the study was carried out to fill this “gap” and to clarify the ancient works of foreign researchers related to Mongolian pharmacology and development of pharmaceutical formulation.

Purpose of the study: To chronologically identify the early works of foreign researchers on the study of pharmacology and pharmaceutical formulation of traditional Mongolian medicine.

Research method: *Hermeneutic approach, analysis of ancient textbook, and analysis and synthesis methods were used.*

Conclusion: *According to facts and eyewitnesses in the book of Zhouhou Beijifang (Emergency Prescriptions) by Ge Hong (261-341) of the Jin Dynasty, Jingui Yaolue (Essential Prescriptions from the Golden Cabinet) by Chang Ji, the Northern Han Dynasty’s notes on “Xiongnu Doctors Carry Toxic Drugs”, Jāmi‘ al-Tawārīkh (Compendium of Chronicles) by Rashid-ad-Din, William de Rubruck’s “Journey to the Orient”, and book of Plano Carpini, an Italian tourist, the development of pharmacology and pharmaceuticals in traditional Mongolian medicine dates back to the Xiongnu period. Later, in the fourteenth century, it became an independent system of medical knowledge of many nations, as evidenced by the writings of Chinese, Persian, French, and Italian scholars as well as religious envoys.*

Keyword: pharmacology, pharmaceutical formulation, traditional Mongolian medicine, foreign researchers

Үндэслэл

Монголчууд эмийн түүхий эд, эм найрлагыг хэрэглэх талаар баялаг мэдлэг туршлагыг хуримтлуулсан бөгөөд Их Монгол Улсыг байгуулсан эзэн богд Чингис хаан өөрийн цэрэгт тусгай эмч ажиллуулдаг байсан бөгөөд 1226 онд монгол цэргийн дотор хижиг өвчин дэлгэрснийг гишүүний үндсээр (Төв:жумза, Лат:Rheum undulatum) анагааж байсан тухай “Юань улсын түүх”-д бичиж үлдээжээ^{1,2}. Эртний Монголд ургамлын онцгой зүйл болох цагаан гоёог эмэнд хэрхэн хэрэглэх тухай “Идээ ундааны жинхэнэ товч”, “Руй-жу тангийн туршлагат жор”, Хятадын алдартай эмзүйч Лиши Жэнгийн бичсэн “Өвсөн эмийн товч” зэрэг олон зохиолд тэмдэглэжээ. Түүнчлэн элстэй (говь) газрын гаралтай улаан утас хэмээх өвсний сүүгээр шархыг анагаадаг байсан нь одоо ч уламжлагдан хэрэглэгдэж байна^{3,4}.

Сүүлийн жилүүдэд Монголын уламжлалт анагаах ухаан (МУАУ)-ы эм судлал, эм найрлагын судалгаа ихээхэн өргөжин хөгжиж байгаа ч гадаадын судлаачдын МУАУ-ны эм судлал, эм найрлагын судлалтай холбоотой эрт цагт туурвисан бүтээл байгаа эсэх, туурвисан бол ямар бүтээлүүд байгаа талаар судласан эрдэм шинжилгээний бүтээл ховор байна. Тиймээс бид энэ “Цагаан толбо”-ыг нөхөх, эм судлал, эм найрлагын судлалтай холбоотой эрт цагийн бүтээлийг тодруулахаар энэхүү сэдвийг сонгон авлаа.

Судалгааны зорилго

Гадаадын судлаачдын МУАУ-ны эм судлал, эм найрлагын судлалтай холбоотой эрт цагийн бүтээлийг он цагийн дарааллаар тодруулан гаргах.

Судалгааны арга

1. Герменевтик арга
2. Эх бичгийн бичгийн судлалын арга
3. Анализ, синтезийн аргыг тус тус хэрэглэв.

Судалгааны үр дүн

Хүннүүд эсгий гэрт амьдарч, малын мах, сүүгээр идээ ундаа болгож, арьсаар нь хувцас хийж өмсдөг байжээ. Тэд өвс ургамал, гол мөрөн даган нүүдэллэнэ. Тиймээс тэднийг “хээр хоногсод” хэмээн нэрлэдэг ч үе байв. Магадгүй умардын нүүдэлчдийн өвс, ургамлыг дагаж байнга нүүдэл хийж, хээр гадаа хоноглодог амьдралын хэвшлийг үндэслэн өгсөн нэр буй заа. Тиймээс тэдний үүдэн бүтээсэн эмчилгээний арга тухайлбал эм найрлагыг “хээр хоногсдын үрэл” гэж нэрлэсэн байна. Уг үрэл нь умард зүгийн хүйтэн ширүүн уур амьсгалаас үүдэн гарсан хүйтэн чанартай дотор өвчинг анагаах тусгай найрлага юм. Харамсалтай нь уг эмийн найрлага, онолын ойлголт, бүрэлдэхүүн нь шууд байдлаар бидэнд уламжлагдаж ирсэнгүй. Гэвч дам байдлаар Хятадын эртний эмч нарын бүтээлээр дамжин иржээ.

Хүннүгийн “хээр хоногсдын үрэл” хамгийн анх Жин улсын Гэ Хун (261-341)-гийн бичсэн “Жоу Хун Фан” гэдэг номонд: “Хээр хоногсдын үрэл бол их хүйтэн чанартай эс шингэсэн өвчинг засах жор” гэж дурдсан байна. Уг үрэлд гаа, шинца, сандуй буурцаг, номхотгосон чулуун хор, сороол тус бүр 3 лан, эдгээр 6 хөл эмийн нунтагийг хонгорцог буюу уянгат модны үрийн хэмжээгээр балт үрэл болгоно. Өдөрт 3 удаа, удаа бүр арван үрлийг архиар даруулж ууна. “Чан Жин Фан” (Хүйтэн чанартай эс шингэснийг засах бүлэг) номд: Чулуун хор 2 лан, шинца 2 лан, бон-а-гийн соёо 2 лан, гаа 2 лан, эдгээр 4 хөл эмийг нунтаглан уянгат модны үрийн хэмжээгээр балт үрэл хийнэ. Энэхүү “хээр хоногсдын үрэл” голдуу хүйтэн, хий өвчин, хэвлийн хэсэг базалж өвдөх, бөөлжих, хүйтэн идэш эс шингэх хийгээд хүйтэнд гэмтэх, өглөө эрт хүйтэнд даарах, болон хүйтэн хийг дарах үйлдэлтэй. “Чан Жи и Фан” (үнэт чухал өөр жор)-д “Хэвлийг ходоодны их үрэл нь голдуу хүйтнээр гэмтсэн архаг чанартай өвчинг туйлбартай засахын зэрэгцээ ханиалгах, огших өвчинг анагаана.

Жорын бүрэлдэхүүнд: Хүн орхоодой, шинца, таранай мод, бона-гийн навч (хальсыг арилгаж номхотгох), шатаасан байван зэргийг хувь тэнцүү авч, эдгээр 5 хөл эмийг нунтаглан, уянгат модны үрийн хэмжээгээр балт үрэл болгож өдөрт 2 удаа, удаа бүрт 3 үрлийг архиар даруулж ууна. Хэмжээг нь тухайн өвчнөөс хамааруулж тогтооно. Хан улсын үед Хүннүчүүд хорт эмийг хэрэглэхдээ дадамгай байсан хэмээн хятадын түүхийн ном сударт эртнээс тэмдэглэгдэж ирсэн байна.

“Хойд Хан улсын бичиг”-т: “Хүннүгийн эмч хорт эм авч явдаг” гэжээ. Энэ нь Хүннүчүүдийн дотор өөрийн тусгай эмчилгээ хийдэг эмч нар байсныг гэрчилж байгаагаар барахгүй тэд хорт эмийг хэрэглэхдээ гарамгай байсны гэрч юм. Хүннүчүүдийн хэрэглэдэг хорт эм бол тэдний нутаг дэвсгэрээс гаралтай эмт бодис болно. Мөн тэдний хэрэглэдэг өвсөн эмийн дотроос бон-а, эрдсийн төрлийн эмийн дотроос чулуун хор хоёр хамгийн гол эм нь байжээ.

Чингис хааны отгон хүү Тулуйн угсааны монгол Хаан Газан болон Монголын эзэнт гүрний Ил Хаант улсын төрийн сайд Рашид ад Дин эмч, түүхч хүн байсан бөгөөд монгол хаадын зарлигаар дэлхийн түүхийн анхдагч хувилбарыг бичиж үлдээжээ. 1301 он гэхэд Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн хэсгүүд, хувь улсууд болох Алтан Ордон улс, Цагаадайн улс, Юань улс, Ил хаант улсын хаадын ордонд тэр цагийн дэлхий дахины товч түүхийг бичихэд бүрэн хүрэлцэхүйц хэмжээний баримт, материал, бичиг, данс, он дарааллын бичиг, сурвалж, хууль зарлигууд архивлагдсан байна.

Рашид ад Дин “Судрын чуулган”-даа “Ойн иргэд Монголчуудын нэгэн адил монгол эмийг сайн мэддэг бөгөөд монгол аргаар сайн эмчилдэг юм” гэж тэмдэглэсэн нь Монголчуудын дунд эм, эмнэлэг, эмнэн засах эрдэм мэдлэг дэлгэрч байсныг баттай гэрчилж байна. “Монголчууд догшин

хүчтэй эм найрлага”-ыг хэрэглэж байсан тухай “Найман нартай ойр, тэдэнтэй залгаа нутагладаг аймгуудын нэг нь Тикин аймаг байсан. Тэдний эзэн нь Кадыр-Буюрук байв. Кадир нь (арабаар) агуу их, хүчирхэг гэсэн утгатай. Эрт үеэс “кадыр”, өөрөөр хэлбэл хүчтэй эм гэдэг байсан боловч одоо хужир буюу хажир гэж нэрлэдэг зарим монгол эм байдаг”^{5,6} гэснээс үзэхэд өвөг Монголчууд нэн эртнээс эмийн зүйлийг амьдрал, практикт хэрэглэсээр иржээ.



Pic 1. Rashid ad-Din Sinan, the author of the *Jāmi' al-tawārīkh* 1247–1318, Source: First Ismaili Electronic Library and Database

Ургамлын гаралтай эм хэрэглэж байсны өөр нэгэн жишээ бол Вильям де Рүбрүк “Дорно этгээдэд зорчсон минь”-д бүтээлд “Мөнх хааны хатан өвчлөөд байхад гишүүний үндсийг авчран нарийн хэрчив. Өвчтэй хатанд гишүүний үндсийн рашааныг бага уулгаад түүгээр цээжийг нь рашаалж өгсөнд удалгүй өвчтний цог заль нь сэргэж дараа өдөр нь өвчтэй хатныг үзэхээр очиход хатан их сайн болсон байв”⁷.

Энэ нь тухайн үед Монголчууд гишүүний үндсийг халуун өвчинд хэрэглэж амжилт олж байсны нэгэн гэрч юм.

Бас зарим эмч гишүүний үндсийг буруу хэрэглэж хүндрэл гаргаж байсан тэмдэглэл ч байдаг. Жишээ нь “Мөнх хааны алтан эдлэлийг үйлдвэрлэж байсан Вильям дархан өвчин хүрсэнд гишүүний үндсийг уулгаж үзсэн чинь хэтэрхий хүндрүүлж орхиод, бараг л алах завджээ” гэж тэмдэглэжээ⁸.



Pic 2. Portrait of William of Rubruck
Source: <http://factsanddetails.com/china>

XIII зууны үед Италийн жуулчин Плато Карпини “Татарын ойн ард уулгалан дайрч, нум сумаар харван шархдуулахад тэд хэдэн ширхэг өвс авч шархны сүвийг нь тагламагц нисэх мэт түргэн зугтана” гэжээ. Энэ мэт туршлага Монгол газарт эдүгээ болтол хэрэглэгдсээр байна⁹. Эдгээр баримтууд нь XIV зуунаас өмнө Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал, эм найрлагын мэдлэг туршлага тун ч баялаг байсныг харуулж байгаа юм.

Чухамдаа XIII зуунаас Монголчууд хоорондоо болон Хятад, Араб, Энэтхэг, Европ зэрэг гадаад улс орнуудтай харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэхийн далимд монголын цагаан гоёо болон амьтны гаралтай эм Хятад, гадаадад тархан, бусад газар, улс орны дан эмийг Монгол оронд авчирч хэрэглэх явдал өргөжжээ.

Ялангуяа тэр үед Сартуул, Уйгар, Арабын эмийн түүхий эд, эм их хэмжээгээр орж ирсэн бөгөөд 1292 онд одоогийн БНХАУ-ын Өвөр Монголын Шилийн гол аймгийн Шулуун хөх хошуунд байх зуслангийн нийслэлд “Сартуулын эмт бодисын хороо” байгуулав. Ингэснээрээ монголчуудад олон янзын эмт бодис, эмийн жортой танилцах боломж олгон Монгол эм судлал, эм найрлагын судлал өргөжин хөгжиж шинэ шатанд дэвшихэд чухал нөлөө үзүүлжээ^{10,11}.

Сартуулын эмт бодисын хороонд хэрэглэж байсан “Сартуулын эмийн жор” хэмээх нийт 36 эвхмэл судар буй бөгөөд уг зохиолыг XIII-XIV зууны үед зохиожээ. Зохиогч нь хэн болох нь одоогоор тодорхойгүй байна.

Ийнхүү XIII-XIV зуунаас эхлэн МУАУ-ны эм судлал, эм найрлагын ухаан газар нутгийн онцлог, онол арга зүйдээ тохирсон мэдлэгийг цогцлоон бүрдүүлж байсныг дээр дурдсан гадаадын судлаач, жуулчдын ном бүтээлээс тодорхой болсоор байна. Мэдлэгийн энэхүү сан нь улмаар XVI зуунаас Энэтхэг, Хятад, Төвөд зэрэг орны эмийн ухааны ололт амжилтыг бүтээлчээр авч хэрэглэх хөрс сууриа тавьсныг гэрчилж байна.

Дүгнэлт

Жин улсын Гэ Хун (261-341)-гийн бичсэн “Жоу Хун Фан” ном, “Чан Жи и Фан” буюу монголоор “Үнэт чухал өөр жор”-ын бүтээл, Хойд Хан улсын бичиг”-т байгаа “Хүннүгийн эмч хорт эм авч явдаг” тухай тэмдэглэл, Рашид ад Дины “Судрын чуулган”, Вильям де Рүбрүкийн “Дорно этгээдэд зорчсон минь” болон Италийн жуулчин Плато Карпини нарын судар номонд буй баримт, гэрч мэдээллээс үзэхэд МУАУ-ы эм судлал, эм найрлагын хөгжил наад зах нь Хүннүгийн үеэс хөгжиж эхэлсэн бөгөөд хойшдоо өргөжин тэлж XIV зуунд олон үндэстний анагаах ухааны мэдлэгээр бүрдсэн бие даасан тогтолцоо

болж байсан нь Хятад, Перс, Франц, Италийн судлаач, шашны элч нарын бичсэн ном бүтээлүүдийн баримтаар батлагдаж байна.

Ном зүй

1. Giovanni da Pian del Carpine. The Story of the Mongols: Whom We Call the Tartars. 2nd Edition. Branden Publishing Company: Inc; 2014, p. 123.
2. Bold Sh. Development of Traditional Mongolian medicine Clarified by the Source Materials.
3. Dissertation for Doctor of Medical Science. Ulaanbaatar: 2006.
4. Болд.Ш. Монголын анагаах ухааны түүх. Дөрөвдүгээр боть. УБ, 2013
5. Namtai Byamba. Historic Development of Mongolian Medicine from XIII to XIV Centuries.
6. Abstract of dissertation for the Ph.D degree in medicine. Ulaanbaatar: 2007, p. 15-16
7. Рашид ад Дин. Судрын чуулган. УБ, 2002, х.98
8. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. 2 дугаар боть, УБ, 2013
9. Вильям де Рүбрүк. Дорно этгээдэд зорчсон минь. УБ, 2012
10. Вильям де Рүбрүк. Дорно этгээдэд зорчсон минь. УБ, 2012
11. Giovanni da Pian del Carpine. The Story of the Mongols: Whom We Call the Tartars. 2nd Edition. Branden Publishing Company: Inc; 2014, p. 123.
12. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Гуравдугаар боть, УБ, 2013, х.117
13. Эрхэмбат Б. Монголын анагаах ухааны түүх. Гар бичмэл

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
Академич Л.Хүрэлбаатар